МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

# МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ ГИШҮҮН ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭР

2026

# ХӨГЖЛИЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУССАН БАЙДАЛ

## “АЛСЫН ХАРАА 2050”

- Бүс нутгийн **худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилөх;**
- Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, **Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах;**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний **эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах;**
- **Нэг орноос** худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод **хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримталах;**
- Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг **шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлэх;**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- Бүгд Найрамдах Солонгос Улс болон **Евразийн эдийн засгийн холбоо,** Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт **худалдааны хэлэлцээрийг байгуулж, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлэх;**

## МОНГОЛ УЛСЫН 2024, 2025 ОНЫ ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- **Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр,** Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулах,
- **Гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх;**

# МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, 2025 он

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБООТОЙ БАЙГУУЛАХ ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭР

## ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ **27.2 ТЭРБУМ $**




### Монгол Улсын экспортын бүтэц, 2025 он

**Уул уурхай**
**93%**

- Зэс 5.8 тб.$
- Нүүрс 5.8 тб.$
- Алт 1.2 тб.$
- Бусад УУБ 1.8 тб.$

**Уул уурхайн бус**
**7%**

- Ноос, ноолуур 396.7 сая.$
- Мах, махан 319.9 сая.$
- Самар 41.8 сая.$
- Арьс шир 3.5 сая.$
- Бусад УУББ 407.2 сая.$

## 2025 ОНД ДЭЛХИЙН **163 ОРОНТОЙ** ГАДААД ХУДАЛДАА ХИЙСЭН.

### ЭКСПОРТЫН СТАТИСТИК

**86** улсад бараа экспортолсон.

| | |
|---|---|
| 89.3% | БНХАУ |
| 6.9% | Швейцар |
| 0.8% | АНУ |
| 0.4% | Иран |
| **0.4%** | **ОХУ** |
| 2.2% | Бусад улс орон |

**0.5%** Экспортын бууралт

Эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, нэхмэл эдлэл зэрэг 11 хэсгийн экспорт буурсан.

### ИМПОРТЫН СТАТИСТИК

**158** улсаас бараа импортолсон.

| | |
|---|---|
| 40.6% | БНХАУ |
| **24.4%** | **ОХУ** |
| 9.6% | Япон |
| 4.1% | БНСУ |
| 3.7% | АНУ |
| 17.6% | Бусад улс орон |

**2.6%** Импортын бууралт

Тээврийн хэрэгсэл, нэхмэл эдлэл, аж үйлдвэрийн бараа, ургамлын гаралтай бүтээгдэхүүн зэрэг 8 хэсгийн барааны импорт буурсан.

## ГОЛ ТҮНШ ОРНУУДТАЙ ХИЙСЭН ХУДАЛДААНЫ ГҮЙЦЭТГЭЛ

| | *Нийт бараа эргэлт* | *Экспорт* | *Импорт* |
|---|---|---|---|
| БНХАУ | 18.7 тэрбум.$ | 14.1 тэрбум.$ | 4.6 тэрбум.$ |
| ОХУ | 2.8 тэрбум.$ | 60.6 сая.$ | 2.8 тэрбум.$ |
| Швейцар | 1.1 тэрбум.$ | 1.1 тэрбум.$ | 29.6 сая.$ |
| Япон | 1.1 тэрбум.$ | 9.1 сая.$ | 1.1 тэрбум.$ |
| АНУ | 544.5 сая.$ | 126.8 сая.$ | 417.7 сая.$ |
| БНСУ | 507.3 сая.$ | 39.0 сая.$ | 468.3 сая.$ |

*Эх сурвалж: ГЕГ*

# МОНГОЛ УЛС, ЕАЭЗХ ХООРОНДЫН ХУДАЛДАА, 2025 он



**МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДААНЫ ХОЁР ДАХЬ ГОЛ ТҮНШ**

## ЕАЭЗХ-ны 5 гишүүн улстай бараа эргэлт, 2.9 тб.$

| *ОХУ* | *Казахстан* | *Беларусь* | *Киргиз* | *Армен* |
|---|---|---|---|---|
| **96.6%** | **2.0%** | **0.7%** | **0.6%** | **0.04%** |




## ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ 2.7 ТЭРБУМ $ АЛДАГДАЛТАЙ ХУДАЛДААНЫ ХАРЬЦАА 97:3

| ЭКСПОРТ | | ИМПОРТ | |
|---|---|---|---|
| 92.8 сая.$ | 444 нэр төрлийн бараа | 2.9 тб.$ | 1916 нэр төрлийн бараа |

## ХУДАЛДААНЫ ХҮНДРЭЛҮҮД

- ЕАЭЗХ-ны ХАА гаралтай бүтээгдэхүүний **импортын татвар 15 - 50 хувь**
- ОХУ-ын махны импорт **квоттой**
- ХАА гаралтай бүтээгдэхүүний техникийн зохицуулалтын **шаардлага өндөр**
- Гаалийн үйл ажиллагаа **хүнд сурталтай**
- Дамжин өнгөрөх **тээвэрлэлтийн саатал, сав баглаа боодлын асуудал**
- ОХУ-ын **тохирлын гэрчилгээ** авахад 4-6 сар хүлээдэг хүндрэлтэй, хүчин төгөлдөр хугацаа 1 жил

# МОНГОЛ-ЕАЭЗХ ХООРОНД ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАХ ЯРИА ХЭЛЭЛЦЭЭНИЙ ЦАГАЛБАР

Хэлэлцээр байгуулахын өмнө зөвлөлдөх **2 уулзалт,** албан ёсны **3 удаагийн хэлэлцээ** хийж 2025.06.26-27-ны өдрүүдэд Бүгд найрамдах Беларус Улсын Минск хотноо ЕАЭЗХ-ны Дээд зөвлөлийн уулзалтын үеэр хэлэлцээрт гарын үсэг зурсан.

**2020.09**

Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд **Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны ажлын хэсэг** байгуулагдсан.

**2021**

Гадаад харилцааны яамны захиалгаар Монгол-ЕАЭЗХ Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нөхцөлд эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судалсан.

**Судалгаанд талуудын бүх барааг хамруулсан.**
**Ашиггүй байх үр дүн гарсан.**

**2022.11.24**

**Монгол-Орос ЗГХК-ын 24 дүгээр хуралдааны үеэр** Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар бүрэн хэмжээний Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах **хэлцлээс гарч байгааг айлын талд мэдэгдэж,** худалдааны хоригийн хэмжээнд өндөр байгаа **ОХУ-ын талын импортын татварыг бууруулах шаардлага тавьсан.**

**2023.09.21**

ОХУ-ын Владивосток хотноо зохион байгуулагдсан Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр **ОХУ-ын ЗГ-ын орлогч дарга Л.Оверчук** ОХУ нь дангаараа импортын татвараа бууруулах боломжгүй тул, **ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэх санал тавьсан.**

**2024.01.28**

Чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах талаар Евразийн эдийн засгийн комисстой **Анхдугаар зөвлөлдөх уулзалт** Улаанбаатар хотноо зохион байгуулав.

**2024.03.13**

Чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах талаар Евразийн эдийн засгийн комисстой **Хоёрдугаар зөвлөлдөх уулзалт** Москва хотноо зохион байгуулав.

**2024.05.08**

Евразийн эдийн засгийн холбооны гишүүн улс орны Ерөнхийлөгч нарын түвшинд зохион байгуулдаг Дээд зөвлөлийн уулзалтаар Монгол Улстай Худалдааны түр хэлэлцээр байгуулах шийдвэр гаргав.

**2024.07.02**

Монгол-ЕАЭЗХ Худалдааны түр хэлэлцээрийн **Эхний шатны хэлэлцээг зохион байгуулав.**

**2024.09.05**

Монгол-ЕАЭЗХ Худалдааны түр хэлэлцээрийн **хоёр дахь шатны хэлэлцээг зохион байгуулав.**

**2025.03.20**

Монгол-ЕАЭЗХ Худалдааны түр хэлэлцээрийн **гурав дахь шатны хэлэлцээг зохион байгуулж, хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцов.**

**2025.04.23**

ЭЗБХ, ТБХ, АБГБ **байнгын хороодоор** хэлэлцүүлж дэмжсэн. Хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгосон.

“Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийг **соёрхон батлах тухай хуулийн төслийг** Монгол Улсын Засгийн газрын 29 дүгээр тэмдэглэлийн дагуу Монгол Улсын Их Хуралд **өргөн мэдүүлж 2025 оны 12 дугаар сарын 12-нд соёрхон батлуулсан.**

Судалгаа гүйцэтгэсэн:
Н.Батнасан (Ph.D)

# ЕАЭЗХ-НЫ ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ - ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАРААХ МАНАЙ ЭКСПОРТЫН БАРААНЫ ӨСӨЛТ

| Гаалийн татвар тэглүүлэх экспортын барааны нэр төрөл (хэлэлцээрийн БТКУС 29 код) | ЕАЭЗХ-ны гаалийн татвар (MFN) | Хэрэгжих гаалийн татвар | Экспортын барааны өсөлтийн хувь |
|---|---|---|---|
| **Үхрийн мах** (020120, 020130, 020220, 020230) | 50% ▼ | 0% | 125% ▲ |
| **Хонь, ямааны мах** (020410, 020421, 020422, 020423, 020441, 020442, 020450) | 15% ▼ | 0% | 125% ▲ |
| **Адууны мах** (020500) | 15% ▼ | 0% | 125% ▲ |
| **Малын дайвар бүтээгдэхүүн** (020610, 020621, 020629, 020641, 020680, 020690, 020890) | 15% ▼ | 0% | 140% ▲ |
| **Хатаасан, утсан мах (жерки)** (021011, 021012, 021020, 021099, 160419) | 15% ▼ | 0% | 140% ▲ |
| **Хиам зайдас, нухаш** (160100, 160210, 160220) | 15% - 20% ▼ | 0% | 140% ▲ |
| **Нөөшилсөн үхрийн мах** (160250) | 20% ▼ | 0% | 140% ▲ |
| **Хонь, ямааны боловсруулсан мах** (160290) | 15% ▼ | 0% | 140% ▲ |
| **Арьсан гар цүнх, үүргэвч** | 13% - 15% ▼ | 0% | 152% ▲ |
| **Савхин хувцас, бээлий, бүс** | 10% - 15% ▼ | 0% | 152% ▲ |
| **Нэхий, хүрэм, хантааз, дээл** | 8% - 10% ▼ | 0% | 152% ▲ |
| **Бүх төрлийн арьс, шир** | 5% ▼ | 0% | 152% ▲ |
| **Желатин** | 5% ▼ | 0% | 42% ▲ |
| **Малын тэжээл, хорголж, хивэг** | 5% ▼ | 0% | 140% ▲ |
| **Муур, нохойн хоол** | 10% ▼ | 0% | 140% ▲ |
| **Ясны шөл** | 12.5% ▼ | 0% | 51% ▲ |
| **Биологийн идэвхт, уураг бодис** | 5% - 8% ▼ | 0% | 51% ▲ |
| **Малын гаралтай бордоо** | 7% ▼ | 0% | 42% ▲ |
| **Саван, гоо сайхны бүтээгдэхүүн** | 7% ▼ | 0% | 42% ▲ |

| Гаалийн татвар тэглүүлэх экспортын барааны нэр төрөл | ЕАЭЗХ-ны гаалийн татвар (MFN) | Хэрэгжих гаалийн татвар | Экспортын барааны өсөлтийн хувь |
|---|---|---|---|
| **Ноос, ноолууран хувцас** | 10% - 18% ▼ | 0% | 134% ▲ |
| **Оёмол хувцас** | 15% - 18% ▼ | 0% | 134% ▲ |
| **Нэхмэл оймс, бээлий** | 10% - 14% ▼ | 0% | 134% ▲ |
| **Сүлжмэл ороолт, алчуур** | 18% ▼ | 0% | 134% ▲ |
| **Эсгий, дэвсгэр, хивс** | 10% ▼ | 0% | 55% ▲ |
| **Боловсруулаагүй ноос, ноолуур** | 5% ▼ | 0% | 55% ▲ |
| **Ноос, ноолууран нэхсэн даавуу** | 10% ▼ | 0% | 55% ▲ |
| **Хөнжил, малгай** | 10% - 15% ▼ | 0% | 84% ▲ |
| | | | |
| **Төрөл бүрийн гоймон** | 13% - 15% ▼ | 0% | 51% ▲ |
| **Чихэр, шоколад агуулсан амттан** | 12% ▼ | 0% | 51% ▲ |
| | | | |
| **Төмс, хүнсний ногоо** | 10% - 13% ▼ | 0% | 51% ▲ |
| **Чацаргана, хөлдөөсөн жимс** | 5% - 8% ▼ | 0% | 51% ▲ |
| **Жимсний чанамал** | 10% ▼ | 0% | 51% ▲ |
| **Жимсний шүүс** | 8% ▼ | 0% | 51% ▲ |
| **Чихэртэй ус ундаа** | 8% ▼ | 0% | 17% ▲ |
| **Цагаан архи** (тариф 25% бууруулна) | 1.5евро/л ▼ | 1.125евро/л | 17% ▲ |
| **Шар айраг** (тариф 25% бууруулна) | 0.04евро/л ▼ | 0.03евро/л | 17% ▲ |
| **Хайлуур жоншны хүдэр, баяжмал** | 10% ▼ | 0% | 17% ▲ |

*Эх сурвалж: www.eec.eaeunion.org, ЭЗХЯ-ны GTAP шинжилгээний тооцоолол*

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБООТОЙ БАЙГУУЛАХ ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭР

# ЕАЭЗХ-ТОЙ ХИЙХ БАРААНЫ ХУДАЛДААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

GTAP Global Trade Analysis Project

- GTAP (Global Trade Analysis Project) ерөнхий тэнцвэрийн загвар
- Загварын үндсэн өгөгдөл нь 160 улсын орц, гарцын хүснэгт (Input-output table) болон худалдаа, макро үзүүлэлтүүдээс бүрддэг.
- Тооцоололд GTAP дата сангийн GTAP 11C database (2024 оны 4 сар) ашигласан.

**367**

***Барааны тоо***

EXPORT **24.2%**

***ЕАЭЗХ-ны улс руу экспорт нэмэгдэнэ***

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүн ЕАЭЗХ-ны зах зээлд илүү хямд болох тул манай экспортын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна. (Импортын квотгүй байхад 24.1% байсан)

IMPORT **0.78%**

***ЕАЭЗХ-оос импорт нэмэгдэнэ***

ЕАЭЗХ-ны импортын бүтээгдэхүүн манай зах зээлд хямд болох тул импортын бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна. (импортын квотгүй байхад 0.97% байсан)

**367**

***Барааны тоо***

| -0.26% | 2.57% | 0.02% | 0.09% | 9.5 сая $ |
|---|---|---|---|---|
| *Хэрэглээний зардал* | *Хөрөнгө оруулалт* | *ДНБ* | *Худалдааны нөхцөл* | *Welfare change* |

Өрхийн хэрэглээний зардал болон үйлдвэрлэлийн зардал буурснаар эдийн засаг дах хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдэж, нийт үйлдвэрлэл өсөж байна.

Худалдааны нөхцөл сайжирч байгаа нь хэлэлцээрийн үр дүнд валютын орох урсгал нь гарах урсгалаас өндөр байхыг харуулж байна.

# **МОНГОЛ УЛС - ЕАЭЗХ 3 ДАХЬ ШАТНЫ ХЭЛЭЛЦЭЭ,** МОСКВА ХОТ, 2025.03.20



## МАНАЙ ТАЛААС ЕАЭЗХ-НД ХҮРГҮҮЛСЭН ХАСУУЛАХ 23 БАРААНЫ ХЭЛЭЛЦЭЭНИЙ ҮР ДҮН

### ХАСУУЛАХ САНАЛЫГ ХҮЛЭЭН АВСАН /8 бараа/

| Барааны нэр | MFN |
|---|---|
| Шингэн сүү | 15% |
| Өтгөрүүлсэн сүү | 5% |
| Шар сүү | 5% |
| Өтгөн цөцгий | 15% |
| Даршилсан өргөст хэмх | 5% |
| Сонгино | 15% |
| Төмс | 20% |
| Шар лууван, манжин | 20% |

| | |
|---|---|
| 2024 ОНЫ ИМПОРТ, $ | 2,350,460 |
| ГААЛИЙН ТАТВАР, $ | 174,752 |

### БУУЛТ ХИЙСЭН БАРААНУУД /11 бараа/

| Барааны нэр | MFN | Тарифын нөхцөл | Хэлэлцээрийн тариф |
|---|---|---|---|
| Сахартай хуурай сүү | 5% | 1500тн квоттой | Тариф тэглэнэ |
| Сахаргүй хуурай сүү | 5% | 1500тн квоттой | Тариф тэглэнэ |
| Хайлмал бяслаг | 15% | Тариф 50% бууруулах | 7.5% |
| Цөцгийн тос | 15% | Тариф 50% бууруулах | 7.5% |
| Бяслаг | 15% | Тариф 50% бууруулах | 7.5% |
| Бусад бяслаг | 15% | Тариф 50% бууруулах | 7.5% |
| Өндөг | 15% | 90 сая.ш хүртэл тариф 50% бууруулах | 7.5% |
| Хатуу улаанбуудай | 5% | Нийт 50 мян.тн квоттой, тариф 25% бууруулах | 3.75% |
| Зөөлөн улаанбуудай | 5% | | 3.75% |
| Шар айраг | 25% | Тариф 25% бууруулах | 18.75% |
| Цагаан архи | 40% | Тариф 25% бууруулах | 30% |

| | |
|---|---|
| 2024 ОНЫ ИМПОРТ, $ | 41,610,265 |
| 2024 ОНЫ ГААЛИЙН ТАТВАР, $ | 4,032,278 |
| БУУЛТ ХИЙСЭН 11 БАРААНААС АВАХ ГААЛИЙН ТАТВАР, $ | 2,100,381 |

### ХАСУУЛАХ САНАЛЫГ ХҮЛЭЭН АВАХГҮЙ /4 бараа/

| Барааны нэр | MFN |
|---|---|
| Иогурт | 15% |
| Амтат жигнэмэг | 5% |
| Өрмөнцөр | 5% |
| Эрдэст ус | 5% |

| | |
|---|---|
| 2024 ОНЫ ИМПОРТ, $ | 33,869,386 |
| ГААЛИЙН ТАТВАР, $ | 2,103,985 |

# МОНГОЛ ТАЛЫН ТОХИРСОН 367 БАРААНЫ ЖАГСААЛТ (ЕАЭЗХ-той 2023 оноор харьцуулсан)

**Манай экспортлогч ААНБ багадаа 1 жилд 16.6 сая ам.$ гаалийн татвар тэглүүлнэ.**

## МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

Татвартай 9 нэр төрлийн бараа **татваргүй 29 болж нэмэгдэнэ.**

**МУ-ын экспорт** (311.6сая.$)

5.8 сая.$

**ЕАЭЗХ руу экспорт**

0.8%

ЕАЭЗХ-ны зах зээлд нийлүүлсэн мах, махан бүтээгдэхүүн

**ЕАЭЗХ-ны эрэлт хэрэгцээ**

706.2 сая.$

**ЕАЭЗХ-ны нийт импорт**

44%

МУ-ын нийт экспорт ЕАЭЗХ-ны импортод эзлэх хувь

## АРЬС, ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН

Татвартай 24 нэр төрлийн бараа **татваргүй 60 болж нэмэгдэнэ.**

**МУ-ын экспорт** (6.4сая.$)

0.5 сая.$

**ЕАЭЗХ руу экспорт**

0.01%

ЕАЭЗХ-ны зах зээлд нийлүүлсэн арьс, ширэн бүтээгдэхүүн

**ЕАЭЗХ-ны эрэлт хэрэгцээ**

6.9 тб.$

**ЕАЭЗХ-ны нийт импорт**

0.1%

МУ-ын нийт экспорт ЕАЭЗХ-ны импортод эзлэх хувь

## НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН

Татвартай 64 нэр төрлийн бараа **татваргүй 204 болж нэмэгдэнэ.**

**МУ-ын экспорт** (452.4сая.$)

2.2 сая.$

**ЕАЭЗХ руу экспорт**

0.1%

ЕАЭЗХ-ны зах зээлд нийлүүлсэн арьс, ширэн бүтээгдэхүүн

**ЕАЭЗХ-ны эрэлт хэрэгцээ**

7.5 тб.$

**ЕАЭЗХ-ны нийт импорт**

6%

МУ-ын нийт экспорт ЕАЭЗХ-ны импортод эзлэх хувь

## ХАА БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН

Татвартай 22 нэр төрлийн бараа **татваргүй 65 болж нэмэгдэнэ.**

- **Сүү, цагаан идээ**
  *Айраг, исгэлэн цагаан идээ, цөцгийн тос*
- **Малын гаралтай**
  *Өлөн гэдэс, яс, дэл сүүл*
- **Малын өөх, тос**
  *Малын өөх, өөхөн тос*
- **МАА, ХАА холбоотой**
  *Гэр, чацаргана, арвай*

## БУСАД бараа

Татвартай 3 нэр төрлийн бараа **татваргүй 9 болж нэмэгдэнэ.**

| | | |
|---|---|---|
| Хайлуур, жонш | → | ЕАЭЗХ |
| Давс, хуванцар | → | ХХААХҮЯ |
| Зэс, молибден, тугалга, гянт болд | → | МҮХАҮТ |

# ЕАЭЗХ ТАЛЫН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ 367 БАРААНЫ ЖАГСААЛТ

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБООТОЙ БАЙГУУЛАХ ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭР

HS8
499ш

## **АЖ ҮЙЛДВЭРИЙН** БҮТЭЭГДЭХҮҮН

**7.5%**
**195 сая.$**
ЕАЭЗХ импортод эзлэх хувь

**222**
**бараа**

| | |
|---|---|
| Өмнө нь нийлүүлдэг | **181 бараа** |
| Шинээр | **41 бараа** |

- ХАА техникийн эд анги
- Мяндсан даавуу
- Төмрийн хайлш
- Ган төмөр эдлэл
- Лифт, турбин
- Трансформатор
- Хүнд машин механизм

Үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад ашиглагдах **техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, төмөр хийц** зэрэг **манай улсын үйлдвэрлэдэггүй бүтээгдэхүүнүүд** татваргүй үнээр орж ирнэ.

## **ХҮНСНИЙ** БҮТЭЭГДЭХҮҮН

**10.8%**
**283 сая.$**
ЕАЭЗХ импортод эзлэх хувь

**94**
**бараа**

| | |
|---|---|
| Өмнө нь нийлүүлдэг | **81 бараа** |
| Шинээр | **13 бараа** |

- Элсэн чихэр
- Кетчуп
- Гахайн мах
- Хуурай сүү
- Өндөг
- Алим
- Хөөлгөгч

Хүнсний бэлэн орц импортын татваргүй болсноор **үйлдвэрлэлийн өртөг буурах** боломжтой. Хүнсний салбарын **тодорхой бараанудад зах зээлийг хамгаалах хязгаарлалтуудыг тусгасан.**

## **ЭРДЭС, ХИМИЙН** БҮТЭЭГДЭХҮҮН

**81.7%**
**2.1 тэрбум.$**
ЕАЭЗХ импортод эзлэх хувь

**51**
**бараа**

| | |
|---|---|
| Өмнө нь нийлүүлдэг | **47 бараа** |
| Шинээр | **4 бараа** |

- Витамин, эм
- Шингэн антибиотик
- Азотын бордоо
- Автобензин
- Дизель түлш
- Шампунь
- Угаалгын нунтаг

Газар тариаланд хэрэгцээтэй **бордоо, хүн амын түгээмэл хэрэглэдэг эм, эмийн бүтээгдэхүүн татваргүй** үнээр орж ирэх боломжтой.

ЕАЭЗХ СОНГОСОН 367 БАРААНЫ 2024 ОНЫ ИМПОРТЫН ДҮН 2,616 САЯ.$

**Хэлэлцээрт НӨАТ, онцгой албан татвар ХАМААРАХГҮЙ.**

**Дотоодын зах зээлийг хамгаалах** талаар хэлэлцээрийн **19 дүгээр заалтад** тусгасан.

**Хүнсний тодорхой бараанууд тоон хэмжээний хязгаарлалт, тарифын чөлөөлөлт бус** бууралт үзүүлэх нөхцөлтэй.

# **ХЭЛЭЛЦЭЭРИЙН ҮР ӨГӨӨЖ** - ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТ



## ХЭЛЭЛЦЭЭРИЙН **ҮР ӨГӨӨЖ, БОЛОМЖ**

- ✓ **ЭКСПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ ТЭЛЖ, ОРЛОГО НЭМЭГДЭНЭ.** Хэлэлцээрийн хүрээнд ХАА-н гол нэрийн барааны экспорт 152% хүртэл өснө. Үр дүнд нь иргэд, 200 мянган малчин өрхийн орлого нэмэгдэж, тогтвортой зах зээлд холбогдох боломж бүрдэнэ.
- ✓ **ТҮҮХИЙ ЭД ХЯМДАРЧ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАРДАЛ БУУРНА.** Хүнсний орц, техник тоног төхөөрөмж, бензин шатахуун зэрэг импортын гол түүхий эдийг татваргүй оруулснаар дотоодын үйлдвэрлэлийн өртөг буурч, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
- ✓ **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ СУУРЬ НӨХЦӨЛ БҮРДЭНЭ.** Худалдааг хөнгөвчлөх, гаалийн шинэчлэл, гарал үүслийн уян хатан шаардлага зэрэг зохицуулалт нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- ✓ **ХЭРЭГЛЭГЧДИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАР САЙЖИРНА.** Гаалийн татваргүй болсон өргөн хэрэглээний барааны үнэ буурч, иргэдийн хэрэглээний зардал багасна. Энэ нь инфляцын дарамтыг 0.7 нэгжээр бууруулах давхар эерэг үр нөлөөтэй.
- ✓ **БИЗНЕСИЙН ТААТАЙ, ӨРСӨЛДӨӨНТ ОРЧИН БҮРДЭНЭ** Гаалийн процесс хялбаршиж, хугацаа хэмнэх, бичиг баримтын ачаалал багасах, ЖДҮ-ийг дэмжих нөхцөл бүрдэж, зах зээл дээр шударга өрсөлдөөн бий болно.
- ✓ **ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХАМГААЛАХ ЗОХИЦУУЛАЛТ ҮЙЛЧИЛНЭ.** Зарим бүтээгдэхүүнд тарифын хөнгөлөлт хязгаарлагдмал хэрэгжих, шаардлагатай тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ авахаар тусгасан нь дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах агуулгатай.

## ХЭЛЭЛЦЭЭРИЙН **ЗАРИМ ОНЦЛОХ** ЗААЛТ

- ✓ ГААЛЬД МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭСНЭЭС ХОЙШ **4 ЦАГИЙН** ДОТОР БАРААГ ОЛГОНО. (13.7.a)
- ✓ ГААЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ **ЦАХИМААР** СОЛИЛЦОНО. (14.8-14.11, 14.7.b)
- ✓ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ-ШАЛГАЛТЫГ ТӨВЛӨРҮҮЛЖ, **БАГА ЭРСДЭЛТЭЙ БАРАА-ГААЛИЙН ШАЛГАЛТЫГ БАГАСГАНА.** (13.7.c)
- ✓ ГААЛИЙН **ИТГЭМЖЛЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨТӨЛБӨР**ИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ. БАРААГ БАЙНГА ШАЛГУУЛАХГҮЙ, ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН БИЧИГ БАРИМТ, ХУГАЦАА, ЗАРДАЛ БОЛОН АЧАА СААТАЛ БАГАСНА. (13.8, 13.9)
- ✓ 5000 ЕВРОГООС БАГА ДҮНТЭЙ БАРАА **ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ШААРДАХГҮЙ** ШУУД НЭВТРҮҮЛНЭ. (Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 21.1)
- ✓ 50 ХУВИАС ДЭЭШГҮЙ ГАРАЛ ҮҮСЭЛГҮЙ МАТЕРИАЛ АШИГЛАСАН, ЭСХҮЛ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТАЛ БОЛОХ 5 УЛСААС ГАРАЛТАЙ МАТЕРИАЛ АШИГЛАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭСЭН БОЛ **МОНГОЛ ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙД ТООЦНО.** (Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм.3)
- ✓ ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ **12 САРЫН ДОТОР НӨХӨН ГАРГАЖ** ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БОЛОМЖТОЙ. (Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 24.3)
- ✓ ЭРҮҮЛ АХУЙ, ХОРИО ЦЭЭР, ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ **ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭЛЭЛЦЭЭ ХИЙХ** БОЛОМЖ БҮРДСЭН.(10.3)
- ✓ **ЦАХИМ ХУДАЛДАА ЭРХЛЭГЧИЙН** ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХӨНГӨВЧЛӨНӨ. (23.3)
- ✓ **ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ** ЦААСАН ГАРЫН ҮСЭГТЭЙ АДИЛ ХҮЧИНТЭЙ.(23.6)
- ✓ **ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ,** ТЕХНИКИЙН СААД ТОТГОРЫГ АРИЛГАХ БОЛОН ХЯЗГААРЛАЛТ ҮҮСГЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ АСУУДЛЫГ **ХАМТАРСАН ХОРОО**ГООР ШИЙДВЭРЛЭНЭ. (10.6, 11.4)
- ✓ **ГААЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ** ЧИГЛЭЛЭЭР БАЙНГА ХАРИЛЦАХ ЭТГЭЭДИЙГ ТОМИЛНО.(14.6)

# ЕАЭЗХ-НЫ ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭН ЯАРАЛТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД

Евразийн эдийн засгийн комисстой Худалдааны түр хэлэлцээрийг хэрэгжүүлэх **ХАМТАРСАН ЗАМЫН ЗУРАГЛАЛ** боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

## СТАНДАРТ

- Талуудын **стандартын зөрүүнд** шинжилгээ хийх.
- Шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг **шинэчлэн батлуулах.**
- ЕАЭЗХ-ны **52 техникийн шаардлага, 49 мянган стандарт**, холбогдох техникийн баримт бичгийг **орчуулж нэвтрүүлэх.**
- Тохирлын үнэлгээний үр дүнг **харилцан хүлээн зөвшөөрөх** механизмын хэрэгжилтийг хангах.
- Экспортын бүтээгдэхүүний стандартын талаарх мэдээллийг **бизнес эрхлэгчдэд хүргэх, платформд байршуулах.**

✓ **2026.03.05 СХЗГ**

## ГААЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Эрсдэлд суурилсан гаалийн хяналт, шалгалтын **журмыг шинэчлэн боловсруулах.**
- Гаалийн мэдээлэл, баримт бичгийг **цахимаар солилцох** эрх зүйн болон техникийн орчныг бүрдүүлэх.
- Талуудын гаалийн байгууллагууд хооронд **урьдчилсан мэдээлэл солилцох** механизмыг бий болгох.
- **Квоттой барааны хяналт**, удирдлагын программ хангамжийг хөгжүүлж нэвтрүүлэх.
- **Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж** (AEO) хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

- **2026.03.30 ГЕГ**

## ХОРИО ЦЭЭР

- ЕАЭЗХ-ны гишүүн улс орнуудтай тус тус хоёр талын **хорио цээрийн протокол байгуулах.**
- Монголын мал амьтан, ургамлын эрүүл мэнд, ариун цэврийн журам, лабораторийн чадавх, итгэмжлэл, сорилтын аргачлалыг **ЕАЭЗХ-ны шаардлагатай харьцуулан үнэлэх,** шаардлагатай дүрэм, журам шинэчлэн батлуулах.
- ХАА гаралтай бүтээгдэхүүн мал амьтны өвчинтэй салшгүй холбоотой байгаа тул **бүсчилсэн эрүүл мэндийн** санаачилга, нэг эрүүл мэндийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- Хорио цээрийн талаар бизнес эрхлэгчдэд **мэдээлэл хүргэх.**
- Экспортын бүтээгдэхүүнд тавигдах эрүүл ахуйн шаардлагын **хэрэгжилтийг сайжруулах.**

✓ **2026.03.06 МЭЕГ**

✓ **2026.02.28 Мах**, махан бүтээгдэхүүний салбарын аж ахуйн нэгжүүдэд зориулсан мэдээлэл, санал солилцох арга хэмжээ

✓ **2026.03.24 Арьс**, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дунд мэдээлэл, хэлэлцүүлэг

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
# **БАЯРЛАЛАА**

Утас: 976-51-263333;

Цахим шуудан: info@med.gov.mn

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн
гудамж Засгийн газрын XI байр

Улаанбаатар 15160

www.med.gov.mn